

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017.12.20

Зорилго: Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Арга зүй: Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2017 оны А/280 дугаар захирамжаар батлагдсан “Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн тайлан, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт, салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явцад 2017 оны жилийн эцсийн тайлангуудад үндэслэн хийв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2017 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус салбарт хамааралтай 27 зорилтын 62 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнтэй хэрэгжсэн 33 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 13 арга хэмжээ, 70.0 хувьтай 3 заалт, эрчимжүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 15 арга хэмжээ байгаа бөгөөд гүйцэтгэлийг 91.0 хувь буюу “Үр дүнтэй” хэрэгжиж байна гэж дүгнэлээ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

		Бүгд	Үүнээс			
			Бүгд	Хоёр. Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах бодлого	Бүгд	Зургаа. Аймаг орон нутгийн талаар тусгайлан оруулах заалтууд
Хяналтад авсан шийдвэрийн тоо		27	25	25	2	2
Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо		62	59	59	3	3
Үүнээс	Үр дүнтэй 100/ 90-100/	33	33	33	0	0
	Тодорхой үр дүнд хүрсэн 70/50-89/	13	13	13	0	0
	Эрчимжүүлэх шаардлагатай 40 /31-59/	1	1	1	0	0
	Үр дүнгүй 0 /0-30/	0	0	0	0	0
	Үнэлэх боломжгүй	15	12	12	3	3
	Тасарсан	0	0	0	0	0
	Үүнээс					
	Зохион байгуулалтаас	0	0	0	0	0
	Хөрөнгө дутагдсанаас	0	0	0	0	1
Биелэлтийн дүн /хувь/		91.0		91.0		0

Эрчимжүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ - "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах арга хэмжээний хүрээн тус аймагт байгуулах үйлдвэрийн санал боловсруулан ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Аймгийн үйлдвэржилтийн зураглал бэлтгэн гаргасан.

Үнэлэх боломжгүй 15 арга хэмжээнээс тус аймагт хамааралгүй 10 арга хэмжээг хяналтанд авсан байгаа тул хасах саналыг хүргүүлсэн. Тус салбарт хамааралтай 5 арга хэмжээ нь энэ онд улсын хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдээгүйгээс хойшлуулсан байна. 2018 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээнд саналаа тусган ХХААХҮЯ, Аймгийн ХОХБХ-т хүргүүлсэн байна.

**1.2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

	Бүгд	Хоёр. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	Зорилт 4. Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын Хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ	
Хяналтадавсан нийтзорилтынтоо	9	8	1	
Хяналтадавсанийт Нийтзорилтынтоо	11	9	2	
Биелсэн 100 %	9	8	1	
Үүнээс	Хэрэгжихшатаандаа	1	0	
	Үүнээс	70.0%	1	0
		40.0%	1	1
		Үр дүнгүй	0	0
		Үнэлэх боломжгүй	0	0
	Хугацааболоогүй	0	0	
	Тасарсан	0	0	
	Үүнээс	Зохион байгуулалтаас	0	0
		Хөрөнгө дутагдсанаас	0	0
	Хэрэгжилтийн хувь	83.3	96.6	70

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 2 зорилтын 11 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнтэй хэрэгжсэн 9 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 1 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ, байгаа бөгөөд гүйцэтгэлийг 91.8 хувь буюу “Үр дүнтэй” хэрэгжиж байна гэж дүгнэлээ.

1.3. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Тайлант хугацаанд ХХАА-н салбарт 3 хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийв. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц 88.0 хувийн биелэлттэй байна. 2017 онд Засгийн газрын тогтоолоор “Хүнсний ногоо”, “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрүүд батлагдсан бөгөөд 2018 оны 1 сараас хэрэгжиж эхэлнэ.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

№	Агуулга	Нийт зорилтын	Хэрэгжилтийн явц										Хувь	
			Тасарсан	Биелэлтын байдал										
				100	90	80	70	60	50	40	30	10		
1	Монгол мал үндэсний хөтөлбөр	5	0	4	0	0	1	0	0	0	0	0	0	94
2	Ус” үндэсний хөтөлбөр	5	0	5	0	0	0	0	0	0	0	0	0	100
3	Сав баглаа боодол хөтөлбөр	3		0	0	0	3	0	0	0	0	0	0	70
	Нийт	13	0	9	0	0	4	0	0	0	0	0	0	88

Хөтөлбөрүүдэд үр дүнтэй хэрэгжсэн 9 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 4 арга байгаа бөгөөд гүйцэтгэлийг 88.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ. Сав баглаа боодол хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

1.4. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ “ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” ХӨТӨЛБӨР БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ХӨТӨЛБӨР

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хөдөө аж ахуйн салбарт хамааралтай 20 зорилтын 84 арга хэмжээг хяналтандаа авч, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан. Төлөвлөсөн арга хэмжээнээс үр дүнтэй хэрэгжсэн 49 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 18 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 6 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 8 арга хэмжээ, хугацаа болоогүй 2 арга хэмжээнд хяналт шинжилгээ хийж, гүйцэтгэлийг 91.0 хувь буюу “Үр дүнтэй” хэрэгжиж байна гэж үнэлсэн.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ “ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ”
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

	Бүгд	Нэг.Хүн нийгмийн хөгжил	Хоёр. Эдийн засгийн тогтвортой хөгжил	Дөрөв. Зөв засаглал
Хяналтад авсан нийт зорилтын тоо	20	4	9	7
Хяналтад авсан нийт зорилтын тоо	84	12	51	21
Биелсэн 100 %	49	9	22	18
Хэрэгжих шатандаа	39	7	29	3
Үүнээс				
70.0%	18	1	17	0
40.0%	7	-	6	1
Үр дүнгүй	-	-	-	-
Үнэлэх боломжгүй	8	2	6	-
Хугацаа болоогүй	2	-	-	2
Тасарсан	-	-	-	-
Үүнээс				
Зохион байгуулалт аас	-	-	-	-
Хөрөнгө дутагдсанаас	-	-	-	-
Хэрэгжилтийн хувь	90.3	97.0	78.0	96.0

Хөгжлийн хөтөч хөтөлбөрт тусгагдсан дараах арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх, үр дүнд дээшлүүлэх шаардлагатай

1. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй фермерүүдийг эзэмшлийн газартай болгож, мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх -Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх талаар Мал аж ахуйн бодлогод тусгасан бөгөөд энэ арга хэмжээг хэрэгжүүлэх тулд ХХААГ ын 2 алба хамтын уялдаа холбоогоо сайжруулан ажил зохион байгуулах, эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй фермерийн судалгааг нарийвчлан гаргах, мэдээллийн сан бүрдээлэх, судалгаанаас үндэслэн бодлогоор дэмжин ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

2.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг аймгийн төв, сумдад бүсчилж хөгжүүлэх /ноос угаах, арьс шир, сүү, сүүн болон мах, махан бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэр цех, айраг савлах, хөхүүр, суран эдлэл хийх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах – Хөрөнгө санхүүтэй холбоотой ажил удааширалтай байгаа бөгөөд энэхүү арга хэмжээнд тулгуурлан аймгийн мэргэжилтнүүд төлөвлөгөөндөө тодорхой тусган сум хөгжүүлэх сангийн зээлээр дэмжих ажлыг зохион байгуулж ажиллах

3.Усалтын системийн ашиглалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх, Биологийн гаралтай бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

4.Бизнесийн жишигт нийцсэн “Худалдааны битүү зах” барих, бөөний худалдааны сүлжээг өргөтгөхөдхувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих - Булган сумын 5-р багийн нутаг дэвсгэрт “Их Азар” ХХК нь битүү зах барихаар бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Цаашид хэрэгжих боломжтой.

5.Аймаг байгуулагдсаны 80 жилийг ойг тусгай төлөвлөгөөнд тусгасан ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

Хугацаа болоогүй 2 арга хэмжээ: Гадаад харилцааг өргөжүүлж шинэ шатанд гарган, бизнес эрхлэгчдийг холбох, шинэ харилцаа тогтоох хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнээс БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй хөдөө аж ахуй чиглэлээр хамтран ажиллах, Европын өндөр хөгжилтэй Холбооны бүгд найрамдах Герман, Бүгд найрамдах Австри улсуудтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарт хамтран ажиллах, нөхцлийг судлах ажлууд энэ онд хийгдээгүй.

Үнэлэх боломжгүй арга хэмжээ - Аймаг суманд хөдөө аж ахуйн үйлдвэр, цех байгуулах арга хэмжээнүүд хөрөнгө санхүүгийн асуудаас ажил хийгдээгүй байна. Хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдүүлэхийн тулд холбогдох газруудад санал хүргүүлж ажилласан байна.

1.4.1 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр болон түүний дэд хөтөлбөрүүд

№	Агуулга	Нийт зорилтын	Хэрэгжилтийн явц										Хувь	
			Тасар сан	Биелэлтийн байдал										
				100	90	80	70	60	50	40	30	10		
1	Газар тариалангийн тогтвортой хөгжил хөтөлбөр	7	0	6	0	0	1	0	0	0	0	0	0	95.8
2	“Хүнсний ногоо” хөтөлбөр	8	0	8	0	0	0	0	0	0	0	0	0	100
3	“Булган жимс, жимсгэнэ” хөтөлбөр	5	0	3	0	0	2	0	0	0	0	0	0	88.0
Нийт		20	0	9	0	0	4	0	0	0	0	0	0	94.6

1.5. ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР

Засгийн газрын тогтоол 7, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, ИТХТ-ийн тогтоол 2, ИТХ-ийн тогтоол 4, Засаг даргын захирамж 14-ын нийт 57 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг үнэлгээг гаргалаа. Үр дүнтэй буюу /90-100 хувь/ хэрэгжсэн 43 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу /50-89 хувь/ хэрэгжсэн 13 арга хэмжээ, Хангалтгүй буюу /10-49/ хувь хэрэгжсэн 1 арга хэмжээ, **биелэлтийн дүн дунджаар 93.5 хувьтай үнэлэгдэв.**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

	Бүгд	Үүнээс											
		Бүгд	Үүнээс						Бүгд	Үүнээс			
			УИХ-ын	Ерөнхийлөгч	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Аймгийн ИТХТ-ийн тогтоол		Аймгийн ИТХ-ийн тогтоол	Аймгийн ЭД-ын захирамж	Засаг даргын албан даалгавар	
Хяналтад авсан	30	10	0	0	7	0	3	20	2	4	14	0	
нийт шийдвэрийн тоо													
Хяналтад авсан нийт	57	21	0	0	18	0	3	36	8	6	22	0	
зүйл, заалтын тоо													
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100/ 90-100/	43	19	0	0	16	0	3	24	6	4	14	0
	Хэрэгжих шатанд 70/50-89/	13	2	0	0	2	0	0	11	1	2	8	0
	Хэрэгжилт хангалтгүй 30 /10-49/	1	0	0	0	0	0	0	1	1	0	0	0
	Хэрэгжээгүй 0 /0-9/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Тасарсан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Үүнээс	Зохион	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	байгууллагаас	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	дутагдса наас	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Биелэлтийн дүн /хувь/		92.8	98.3	0.0	0.0	96.6	0.0	100.0	88.8	87.5	90.0	89.0	0.0

Хяналтад авсан заалтуудаас бүрэн хэрэгжсэн, үйл ажиллагаа нь тогтмолжсон, 2 шийдвэрийн 7 заалтыг хасуулах саналыг журмын дагуу Аймгийн ХШҮТ-т хүргүүлж байна. Хэрэгжилт хангалтгүй 1 арга хэмжээ нь төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулах гэсэн заалт байна. Аймгийн хэмжээнд 700 гаруй иргэд жилдээ 500-600 га талбайд төмс хүнсний ногоо тариалдаг ч 90.0 -95.0 хувь нь 5 хүрэхгүй га талбайд тариалдаг учраас механикжуулахад хүндрэл учирч байна. Ногоочдыг суманд нь бүлгийн зохион байгуулалтанд оруулж, дундын техникээр хангах талаар сумдын Засаг дарга нарын гэрээнд жил бүр тусгадаг ч энэ ажил хэрэгждэггүй. ТЭДС-аас урт хугацааны хөнгөлөлттэй нөхцлөөр бага оврын иж бүрдэл ирдэг боловч бага талбайд тарьдаг, орлого багатай иргэд урьдчилгаа төлөөд авч чаддаггүй байна.

1.6. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлж, Үр дүнтэй буюу /90-100 хувь/ хэрэгжсэн 2 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу /50-89 хувь/ хэрэгжсэн 3 арга хэмжээ, **биелэлтийн дүн дунджаар 82.0 хувьтай үнэлэгдэв.**

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

№	Агуулга	Нийт зорилтын тоо	Үүнээс								Нийт хувь 2017
			100	90	70	60	50	30	10	0	
ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
1	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого	5	2	-	3	-	-	-	-	-	82.0

1.7.БУЛГАН АЙМГИЙГ 2016-2021 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ БОДЛОГО

Булган аймгийг 2016-2021 онд хөгжүүлэх цогц бодлогод 3 стратеги зорилтын хүрээнд 15 арга хэрэгжилтийг ханган ажилласан. Үр дүнтэй буюу /90-100 хувь/ хэрэгжсэн 9 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу /50-89 хувь/ хэрэгжсэн 4 арга хэмжээ, Хангалтгүй буюу /10-49/ хувь хэрэгжсэн 1 арга хэмжээ, ажил зохион байгуулаагүй 1 арга хэмжээ, **биелэлтийн дүн дунджаар 89.2 хувьтай үнэлэгдэв.**

БУЛГАН АЙМГИЙГ 2010-2021 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

		Бүгд	4.1. Макро эдийн засгийн бодлого	4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого /2016- 2021/	
Хяналтадавсан нийтзорилтынтоо		3	1	2	
Хяналтадавсаннийт Нийтзорилтынтоо		18	2	16	
Үүнээс	Биелсэн 100 %	9	2	7	
	Хэрэгжихшатаандаа	9	-	9	
	Үүнээс	70.0%	4	-	4
		40.0%	1	-	1
		Үр дүнгүй	0	0	0
		Үнэлэх боломжгүй	0	0	0
	Хугацаа болоогүй	0	0	0	
	Тасарсан	1	0	1	
	Үүнээс	Зохион байгуулалтаас	0	0	0
		Хөрөнгө дутагдсанаас	0	0	0
Хэрэгжилтийн хувь		89.2	100	78.4	

Хяналтад авсан заалтуудаас хамааралгүй 3 арга хэмжээг хасуулах саналыг журмын дагуу Аймгийн ХШҮТ-т хүргүүлж байна. Бугат сумын олон наст таримлын туршилтын үрийн аж ахуйг түшиглэн Хангайн бүсийн аймгуудийн тариалангийн талбайгаас хасагдсан атаршсан талбайг олон наст ургамлаар тарималжуулах – гэсэн арга хэмжээг зохион байгуулах ажил хийгдээгүй байна.

1.7. БУЛГАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Булган аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээнд ХХАА-н салбарын холбоотой 9 зорилт арга хэмжээ тусгагдсанаас 2017 оны хэрэгжилт 97.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

БУЛГАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2017 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үзүүлэлт	2016 оны ХБГ	2017 оны зорилт	2017 оны зорилтын хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6
1	Нийт малын тоо /мян.толгой/	3.4	3.4	3.6	100
	Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь	15.0	15.5	15.5	100
	Инженерийн хийцтэй шинээр гаргах худгийн тоог нэмэгдүүлэх	11	12	29	100
	Сэргээн засварлах худгийн тоо	4	-	0	0
	Иргэдийн гаргах гар худаг	3	5	12	100
	Бэлтгэх хадлан /мян.тн/	98.8	88.5	68	76.5
	Тэжээлийн ургамал /тн/	200	300	665.9	100
	Хураан авсан үр тариа /мян.тн/	53.0	25,8	25.7	99.6
	Хураан авах хүнсний ногоо /мян.тн/	1.0	1.0	1.0	100
Хэрэгжилт					97.0

1.8. ХАА-н салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжээгүй. Өмнөх онд хэрэгжиж байгаад хаагдсан “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөлтэй 25.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 60м² талбай бүхий өвлийн хүлэмж баригдсан байна.

II. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧТАЙ БАЙГУУЛСАНҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ

Газрын дарга Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд ний бүтээгдэхүүн 90 арга хэмжээ, тусгай захиалагат 16 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг 89.7 хувь буюу “Хангалттай” гэж үнэлэв.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧТАЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Гэрээний үзүүлэлт	Бүтээгдэхүүний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт	90	0-30	26.4
Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	16	0-40	34.5
Манлайллын зорилт(орц)-ын биелэлт	5	0-30	28.8
Нийт оноо	110	0-100	89.7

2.2. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Хэрэгжүүлэх зорилт	Хувь
“Хүнс, хөдөө аж ахуйн газрын нийтлэг үйлчилгээг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	91.4
“Хүн амыг тэжээллэг аюулгүй хүнсээр тогтвортой хангах ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	92.4
Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ	90.7
“Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	91.9
“Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс сэргийлэх ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	97.2
“Өмчлөгчийн эрхийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	100
Дундаж оноо	94.0

2017 онд стратегийн 6 зорилтын хүрээнд 71 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний биелэлтийн тайлан үр дүнгийн хүрсэн түвшинд үндэслэн хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл 94.0 хувьтай дүгнэгдэв.

2.3. ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Үзүүлэлт	үнэлгээ
Аймгийн хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн зөвлөмж	100
Дотоод аудитын 2016 оны зөвлөмжийн хэрэгжилт	83.6
ХХААЯ-ны дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилт	100
Аймгийн Аудитын газрын зөвлөмжийн хэрэгжилт	100
Дундаж үнэлгээ	95.9

III БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг үндэслэн хийлээ. ХХААГ-ын 2017 оны байгууллагын ил тод байдлын үнэлгээ 90.0 хувьтай байна.

ХХААГ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал	100
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;	90
Дундаж үнэлгээ	90.0 хувь

а/ Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал

- ✚ Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл хэрэгжүүлэх хүрээнд аймгийн засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр болон Засаг дарга, сайдтай байгуулсан гэрээ, дэд хөтөлбөрүүд, бодлого шийдвэрт тусган ажиллаж байна.
- ✚ Салбарын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм журам, хэрэгжиж буй хөтөлбөр арга хэмжээний жагсаалтыг гаргаж, мэдээллийн самбар, вэб сайтад байршуулсан. /<http://bulgan.hhaag.gov.mn/>
- ✚ Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам”, өргөдөл гомдол хүлээн авах хариуцсан ажилтныг томилон газрын даргын 2015 оны А/18 тоот тушаалаар батлуулж, хэрэгжүүлэв. Мөн иргэдээс гарсан гомдол санал хүсэлтийг хүлээн авах албан тушаалтан, утасыг вэб сайтад байршуулсан. 2017 онд нийт 19 өргөдөл хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн мэдээг хобогдох газруудад хүргүүлж ажиллаа. Мэдээ улирал бүр гаргаж вэб сайт болон мэдээллийн самбарт байршуулж байна. http://bulgan.hhaag.gov.mn/?page_id=2733
- ✚ Монгол мал” үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2017-2020 онд Мал аж ахуй талаар баримтлах бодлогыг аймгийн Засаг зөвлөлийн хурал болон иргэний танхимд сумдын мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, вэб сайтад байршуулан иргэдийн санаа бодлыг тусгасан. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, шинэчлэх хүрээнд сумдын малчид, мал бүхий иргэдээс бэлчээрийг хэрхэн хамгаалах сайжруулах талаар санал асуулга авсан. Санал асуулгын дүнгээр малчид малын хөлийн татвар авах, бэлчээрийг хуваарьтайгаар сэлгэж ашиглах талаар ихээхэн санал ирүүлсэн байна. /<http://bulgan.hhaag.gov.mn/>

- ✚ Аймгийн Засаг даргын 2017 оны 1/450 дугаар захирамжаар Булган аймгийн “Хөгнө Мээж” ТББ-тай хамтран махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн үхэр сүрэгт ангилалт хийх ажлыг зохион байгууллаа.
- ✚ Байгаль хамгаалах сангаас аймгийн хэмжээнд 10-н булаг шандын эхийг хашиж хамгаалахад нийт 35.5 сая төгрөг өртөг бүхий ажлыг хийхээр нөхөрлөл аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэсэн. /<http://bulgan.hhaag.gov.mn/>
- ✚ Аймгийн Засаг даргын 2017 оны 10 сарын 31-ны өдрийн А/546 дугаар захирамжаар Могод, Гурванбулаг, Рашаант, Дашинчилэн, Орхон, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Сайхан сумдын 40.0 мян га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулсан. МХГ-ын ургамал хорио цээрийн хяналтын байцаагч, ХХААГ-ын МААА-ны дарга нартай хамтран 7 суманд гэрээний хэрэгжилт, материалд хяналт хийж, зөвлөгөө өгч ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 худаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 10 худаг, малчдын санаачилгаар 12, нийт 29 худаг шинээр гаргалаа. Үүний үр дүнд 40.0 гаруй мянган га бэлчээр усжуулж, 110.0-аад мянган толгой малыг усаар хангах нөхцлийг бүрдсэн. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөлтэй 25.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 60м² талбай бүхий өвлийн хүлэмж барих ажилд хяналт тавих БУ/ХУ/007 дугаартай гэрээг байгуулан ажилласан. Өвлийн хүлэмжийн ажлын явцад ХХААХҮЯ-ны ГТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Ж.Төмөрхуяг, ЗЗББУХТ-ийн мэргэжилтэн Б.Оюунтуяа, НӨС-ийн зохицуулагч З.Насандэлгэр болон аймгийн ХХААГ-ын дарга Ч.Амгалан, ҮХҮА-ны дарга Б.Энхбаяр, Г.Гантулга, Хутаг-Өндөр сумын Засаг даргын П.Итгэлбаяр, сумын ажлын хэсэгтэй хамтран 2 удаа хяналт тавьж, хүлээн авсан. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан ажлын тайланг төслийн нэгжид хүргүүлсэн. /<http://bulgan.hhaag.gov.mn/>
- ✚ Байгууллагын албан хаагчдыг салбарын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зорилгоор байгууллагын үйлчилгээний стандартыг /CS63:15:2014/ боловсруулан СХЗХ-ээр батлуулж, албан хаагчдын ҮДГ-нд тусган хэрэгжилтийг тооцон ажиллаа.

б) Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

- ✚ Хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээнд ажилчин албан хаагчдыг албан тушаал, холбоо барих утасны жагсаалтыг вэб сайтад байршуулсан. Байгууллагын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх төлөвлөгөө, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ✚ Газрын даргын 2014 оны А/60 дугаар тушаалаар байгууллагын албан хаагчдын мөрдөх “Ёс зүйн дүрэм”-ийг батлуулж, мөрдөн ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч гараагүй. /<http://bulgan.hhaag.gov.mn/>
- ✚ Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоол, Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 01/1497 тоот албан бичгийг тус тус үндэслэн газрын даргын тушаалаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн нийт 40 орон тоогоор баталж, ажилчин албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, газрын даргатай 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулж, хэрэгжилтийг дүгнэн ажиллаа. Нийт 39 ажилчин, албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс төрийн захиргааны албан хаагч 13, төрийн үйлчилгээний албан хаагч 17, гэрээт 7 ажилтан ажиллаж байна. Төрийн захиргааны 15 албан хаагч зэрэг дэвийн нэмэгдлийг 15-20 хувиар, төрийн үйлчилгээний 7 албан хаагчид ур чадварын нэмэгдэл 20-25 хувиар тооцон олгож байна.
- ✚ 2017 онд малын эмч, улсын байцаагч Б.Хишигбаярт зэрэг дэвийн нэмэгдэл 17 хувь, мэргэжилтэн Д.Мөнхбаасанд удаан жилийн нэмэгдэл 10 хувь, С.Энхцэцэгт 20 хувь, Ц.Бямбацогтод 15 хувийн удаан жилийн нэмэгдэл олгох газрын даргын тушаал гарсан. Нийт албан хаагчдад унаа хоолны зардлыг батлагдсан төсвөөр сар бүр олгож байна.
- ✚ Байгууллагын албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх төлөвлөгөөг батлуулан сургалт арга хэмжээнд хамруулж ажилласан. Гадаад сургалт, ажлын айлчлалд Газрын дарга Ч.Амгалан Япон, Хятад, ҮХҮА-ны дарга бөгөөд ерөнхий агрономч Б.Энхбаяр, малын их эмч Р.Түмэн-Эрдэнэ ОХУ-д, малын их эмч С.Уянга Бээжин хотод 7-21 хоног явж, мэргэжил ур чадвараа нэмэгдүүлсэн. Мөн давхардсан тоогоор 11 албан хаагчид улс, аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтуудад хамруулсан байна.
- ✚ Төрийн албанд ахмад үеийнхээ мэдлэг чадвар, туршлага арга барил, хандлагыг тусган авч ажил хэрэг болгох зорилгоор ахмад, дунд залуу үеийн 3 цагийн хэлхээнд хамтран ажиллахаар байгууллага дээр “Зөвлөн туслагч-өвлөн сургалцагч”- аар 5 ахмад, 5 мэргэжилтнийг сонгон ажиллах тушаал гарсан.

в/ Төсөө, санхүүгийн ил тод байдал

- ✚ Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 01/1497 тоот албан бичгийг тус тус үндэслэн газрын даргын тушаалаар байгууллагын бүтэц орон тоог баталсан. Байгууллагын 2016 оны санхүүгийн тайланг гаргаж, хуулийн хугацаанд Аймгийн Аудитын газраар хянуулж, дүгнэлтийг вэб сайтад байршуулав.

- ✚ Төсвийн төслийг байгууллагын стратегийн зорилтод нийцсэн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн, мөн жилийн төсвийн хязгаарт үндэслэн боловсруулж байна. Батлагдсан нийт төсөв 444 795 700 төг, орлого 1 035 000 төг, төсвийн гүйцэтгэл 12 сарын байдлаар 431 245 200 мян.төг-г зарцуулж төсвийн гүйцэтгэл 97.0 хувь, орлого 103 хувьтай байна. /Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 100.0/
- ✚ Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, гарсан зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлсэн.
- ✚ Газрын санхүүгийн тайлан болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагын bulgan.hhaag.gov.mn цахим хаяг болон Шилэн данс хуудсанд байршуулж байна. ХХААХҮЯ-аас ирсэн чиг үүргийн дагуу 7 дугаар сард Шилэн дансны сайтад газрын даргын тушаалаар дотоод хяналт шалгалт хийхэд хугацаатай 39 мэдээлэл оруулахаас хугацаандаа орсон 25, хугацаа болоогүй 10, хугацаа хоцорсон 4 зөрчлийг арилгаж цахим хуудсанд байршууллаа. 11 дүгээр сарын 28-ны байдлаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллүүд хугацаандаа бүрэн орсон байна.

Д./ Байгууллагын шударга байдлын түвшиний үнэлгээ

- ✚ 2017 оны байгууллагын “Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” хэрэгжилт 91.0 хувьтай дүгнэгдэв.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар захирамж, Засгийн газрын 190 дүгээр тогтооыг хэрэгжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг “ХҮЛЭЭЖ СУУХГҮЙ, ХҮРЧ ҮЙЛЧЛЭ” уриан дор зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж аймгийн төвийн 6 багт ажиллаа. Энэ ажлын хүрээнд Булган сумын 6 багийн иргэдэд салбарын холбогдолтой 16 төрлийн тараах материал 180 ширхэг бэлтгэн хүргэж ажилласан.

Иргэдийн санал хүсэлтийг нээлттэй хүлээн авч, шийдвэрлэх **70342134** дугаарын утсыг ажиллуулж, байгууллага дээр санал хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулав. Мөн сум багт хүрч ажиллахаас гадна байгууллага дээр иргэдэд нээлттэй үйлчлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын тамгын газраас 2017 оны 10 дугаар сарын 16-19-ны өдрүүдэд 6 багийн төвд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж тус өдрүүдэд иргэдээс байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн үнэлгээг авч 58 иргэн

хамрагдсанаас 25 иргэн “Хангалттай сайн”, 21 нь “дунд зэрэг” 12 иргэн хангалтгүй гэж асуулгыг бөглөсөн байна. Үүнд бид дүн шинжилгээ хийж, цаашид байгууллагын үйл ажиллагааг хэрхэн эрчимжүүлэх, иргэдэд түргэн шуурхай хүргэх талаар байгууллагын хамт оны хурлаар хэлэлцэн шаардлагатай арга хэмжээг авлаа. ХХААГ-ын салбарын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр авах цонх ажиллуулж байгаа бөгөөд 12 сарын байдлаар энэхүү үнэлгээний дүн сайн-73.0 хувь, дунд-20.0, муу-7 хувь, мэдэхгүй-0 хувийн үнэлгээтэй байна.

Ү. 2017 ОНД ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛСАН

АЖЛУУД

- ✓ “Булган жимс” хөтөлбөр батлуулж, “Чацаргана” төсөл хэрэгжүүлж 2017 онд 174 га талбайд тариалалт хийж, уг төсөлд 16 сум, 1 тосгоны 727 өрхийн 898 иргэн буюу төрийн албан хаагч 297, хувийн хэвшлийн албан хаагч 94, хувиараа бизнес эрхлэгч 133, малчин 120, ажилгүй иргэн 254 тус тус хамрагдаад байна. Энэхүү төслийн хүрээнд 200 га талбайг хашиж хамгаалан, усалгааны 22 худаг гаргасан.
- ✓ 13 суманд зохион байгуулсан малчид, төлчдийн зөвлөгөөнд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр, Малын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомжийг таниулан сурталчлах талаар илтгэл мэдээлэл тавьж, малчдын санал хүсэлтийг сонсож, зарим асуултанд шуурхай хариулт өглөө. Зөвлөгөөнд ойролцоогоор 2300-аад малчид оролцож мэдээлэл сонссон.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 худаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 10 худаг, малчдын санаачилгаар 12, нийт 29 худаг шинээр гаргалаа. Үүний үр дүнд 40.0 гаруй мянган га бэлчээр усжуулж, 110.0-аад мянган толгой малыг усаар хангах нөхцлийг бүрдсэн.
- ✓ Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Бруцеллез, малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 100 хувь хамрагдсан.
- ✓ Улсын хэмжээнд жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний мэдээллийн каталогт 14 сумын 34 иргэн, ААН, хоршоо, бүлгийн давхардсан тоогоор 30 төрлийн бүтээгдэхүүн орсоноор борлуулалтын сүлжээнд хамрагдах боломжтой болсон.
- ✓ Аймгийн Засаг даргын А/550 дугаар “Хяналт шалгалт хийх” тухай захирамж, ХХААГ-ын даргын баталсан Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 16 суманд ЖДҮДС, СХС-ийн зээлийн хэрэгжилт, зориулалт, эргэн төлөлтөнд хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллаа. Шалгалтын явцад гарсан зөрчил дутагдлыг арилгах зөвлөмжийг бүх сумдад

хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтээс харахад сум хөгжүүлэх сангийн баримт бичгийг журмын дагуу боловсруулан сумд өөрийн орон нутгийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, уялдуулан зээл гаргах ажлыг эхэлсэн, мөн шинээр олгосон зээлийн зориулалтанд хяналт тавих ажлууд эрчимжсэн байна. Хугацаа хэтрэлттэй, зориулалт бус 949 056 087 төгрөгийн 179 төслийг зөвлөмжийн дагуу шүүхэд шилжүүлж, 12 сарын 20-ны байдлаар Сум хөгжүүлэх сангийн дансанд 261 883 898 төгрөг төвлөрөөд байна.

ҮІ. ДҮГНЭЛТ

- ✚ Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгийн ерөнхий үнэлгээ ... хувь буюу “Хангалттай” гэж дүгнэгдэж байна.
- ✚ Аймгийн Мал аж ахуйн талаар баримтлах бодлого, Бэлчээрийн менежментийн талаар баримтлах бодлого, “Булган жимс” хөтөлбөр батлуулж, Засгийн газрын хөтөлбөр, аймгийн хөтөлбөр, салбарын бодлого шийдвэр, түүнийг сурталчлах, сургалт мэдээллийн арга хэмжээг сум орон нутагт сайн зохион байгуулсан.
- ✚ 2017-2018 онд 16 сум 1 тосгон, 75 багийн 8.8 мянган малчин өрхөд 3.4 сая толгой мал өвөлжиж, хаваржсан.
- ✚ Хураан авсан ургац өмнөх оноос үр тариа 28000 тн-оор, үүнээс буудай 27679,5 тн-оор төмс 1623 тн-оор, хүнсний ногоо 1202 тн-оор буурсан.
- ✚ Жимс, жимсгэнэ тариалалт 647.37 га-д хүрч өмнөх оноос 174 га-аар нэмэгдсэн.
- ✚ 2017 оны төмс, хүнсний ногооны тариалалтаар хүн амын төмсний хэрэгцээг 100.0 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 16.5 хувиар хангаж байгаа нь хүнсний ногооны хангамж буурсан үзүүлэлттэй байна.
- ✚ Аймгийн хэмжээнд 2017-2018 оны мал өвөлжилт хаваржилтийн бэлтгэлийг 83.8 хувиар хангасан.
- ✚ Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн

ҮІ. ЗӨВЛӨМЖ

- ✚ Сумдын МЭҮТ-ийн мэргэжилтнүүдийг орон тоогоор ажиллуулах, мэргэжилтний мэдлэг чадварийг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг өндөрсгөх ажлын байрны чиг үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих
- ✚ Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, худаг уст цэг гаргах арга хэмжээнд хяналт тавих
- ✚ Цөм сүрэг, эрчимжсэн мал аж ахуйн судалгааг нарийвчлан гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх
- ✚ Бог малын чанарыг сайжруулахад анхаарч ажиллах
- ✚ “Мах сүү аян”-ы төлөвлөгөө гарган хэрэгжилтийг эрчимжүүлэх

- ✚ “Эрүүл хүнс, эрүүл монгол хүн” зорилтын хүрээнд сургалт, мэдээллийг хийх
- ✚ Үйлдвэржилтийн бүсийн ажлыг эрчимжүүлэх, газар авсан иргэдтэй уулзалт зохион байгуулах
- ✚ Малын эмийн зохистой хэрэглээ гарын авлага, ном товхимол бэлтгэхэд мэдээлэл оруулах
- ✚ Малын туулгалт, угаалгын арга хэмжээг хэрэгжүүлэх хяналт тавьж ажиллах
- ✚ Сум бүр өөрийн хүн амын төмс, хүнсний ногооны тариалалтын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- ✚ “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- ✚ Аймаг байгуулагдсаны 80 жилийг ойн арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг эрчимжүүлэх
- ✚ “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан удааширалтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх
- ✚ ЖДҮДС-н төслийн сонгон шалгаруулалтыг хийхдээ аймгийн тэргүүлэх чиглэлийг барьж, СХС-ийн зээлийн хэрэгжилтэнд хяналт тавих

ТАЙЛАН БИЧСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Ч.ШҮРЭНЦЭЦЭГ

БАТАЛГААЖУУЛСАН:
ГАЗРЫН ДАРГА Ч.АМГАЛАН

2017 оны 12-р сарын 20-ны өдөр

**БУЛГАН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

(2016 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		Хувь	Оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	89.0	4.4
		2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	92.0	4.6
		3. Хуулийн хэрэгжилтийн мэдээ	100.0	5.0
		4. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт	97.2	4.8
		5. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	94.0	4.7
		6. Булган аймгийг 2010-2021 онд хөгжүүлэх цогц бодлогын хэрэгжилт	80.4	4.02
		7. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	92.7	4.6
		8. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	88.1	4.4
		9. УИХ, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	93.9	4.69
		10. Аймгаас гаргасан хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилт	95.0	4.75
		11. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт	100.0	5.0
		12. Тухайн салбарыг хөгжүүлэхээр гаргасан аймгийн бодлогын хэрэгжилт	90.0	4.5
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	95.8	4.79
		2. Салбарын удирдах дээд байгууллагын үнэлгээ	-	-
		3. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	94.3	4.7
		4. Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлын	100.0	5.0

		шийдвэрлэлт		
		5. Сарын мэдээ ирүүлэлт, чанар	100.0	5.0
		6. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	94.6	4.73
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	99.0	4.95
		2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	87.5	4.3
		3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	100	5.0
		4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	-	-
		5. Байгууллагын шударга байдлын түвшиний үнэлгээ	97.6	4.8
4	Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ	1. Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	92.6	4.63
		2. Хэрэглэгчийн үнэлгээ	91.8	4.59
Ерөнхий үнэлгээ			94.1	4.6

ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ